# НИЙСЛЭЛИЙН
# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/24 Улаанбаатар хот

Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” 301 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны “Аргачлал, загвар батлах тухай” 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх, тайлагнах үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Дарга | Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга |
| Гишүүн | Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга | Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн |

2.Үнэлгээний багийн гишүүдэд нууцын баталгаа гаргаж, мэдээллийг задруулахгүй байхыг үүрэг болгосугай.

3.Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг зохих хууль тогтоомжийн дагуу үнэлж, дүгнэн, тайлагнаж ажиллахыг үнэлгээний багт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

9024010070 СТС4589 9077448

D:\orshih\2024\A tushaal.docx